



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2017.10.31 № 14

Асуулга тавих тухай

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ё.Баатарбилэг, Ж.Батзандан нар Шинжлэх ухаан, технологийн тухай болон Шинжлэх ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байгаа бөгөөд төсөл боловсруулахтай холбогдуулан Танд дараах асуулгыг тавьж байна.

Нэг. Шинжлэх ухааны Академийн үйл ажиллагааны зардлыг урсгал зардал, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөл хөтөлбөрт зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалтын зардлын талаар,

Хоёр. Төрийн байгууллага, яам агентлагуудын захиалгаар хийгдсэн болон хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үүнээс олон улсын байгууллагууд, гадаад орнуудын дагнасан болон хамтарсан санхүүжилтээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, зарцуулсан хөрөнгийн хэмжээ,

Гурав. Шинжлэх ухаан, технологийн салбарт сүүлийн 5 жилд /2012-2017/ улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ /жил жилээр/, түүний ДНБ-д эзлэх хувь, үр дүн, өгөөж, цаашид шинжлэх ухааны салбарт төрөөс баримтлах бодлогын талаар,

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.БАТТӨМӨР

Ё.БААТАРБИЛЭГ

Ж.БАТЗАНДАН